



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
<http://www.parliament.mn>

2022.06.10

№ 29

Эрчим хүчний хангамжийн
найдвартай байдлын талаар

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 4.2.34-т “Эрчим хүчний найдвартай, аюулгүй, тогтвортой байдлыг хангах дулааны цахилгаан станцуудын хүчин чадлыг өргөтгөж, шинэ цахилгаан станц барьж дотоодын хэрэгцээг бүрэн хангаж, цахилгаан эрчим хүч экспортолно.”, 4.2.37-д “Сэргээгдэх эрчим хүчний суурилагдсан чадлыг 30 хувьд хүргэх, гадагш урсгалтай гол, мөрний урсцын 10 хувийг эрчим хүчний үйлдвэрлэл болон бусад хэрэгцээнд ашиглана”, 4.2.38-д “сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийн орчин үеийн дэвшилтэт технологийг түшиглэн орон нутгийн дулаан хангамжид ашиглах” зорилтуудыг тусгасан.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн Танд дараах асуултгыг тавьж байна. Үүнд:

1. Монгол Улсын эрчим хүчний хангамжийн найдвартай байдал, өсөн нэмэгдэж байгаа хэрэглээг бүрэн хангах талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар;
2. Өмнөд.govийн бүс нутгийн уул уурхайн цахилгааны хэрэглээг хангах, Тавантолгойн уурхайн нүүрсээр ажиллах цахилгаан станцыг барих талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, тулгамдаж буй асуудал, Улаанбаатар хотыг тэлэх хөгжлийн бодлогын хүрээнд барихаар төлөвлөж байсан ДЦС-5 төслийн талаар;
3. Эрчим хүчний салбар 2020 онд 92 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан бол 2021 онд 75,8 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Энэхүү алдагдлыг бууруулах, эрчим хүчний үр ашигтай загварыг хөгжүүлэх чиглэлд хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар;
4. Эрчим хүчний дотоодын хэрэгцээг бүрэн хангасан, тогтвортой, өөрийгөө зохицуулах чадвар бүхий системийг бүрдүүлэх чиглэлд авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар;
5. Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт Эрчим хүчний


салбарт тусгагдсан төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал;

6. Сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэх чиглэлд авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, Сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэхийн давуу болон сул талууд, тулгамдаж буй асуудлууд;

Энэхүү асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэгт заасны дагуу ирүүлж, цаашид Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахад бэлтгэхийг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ГИШҮҮН



2022000070